



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 6/501

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын  
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/110 дугаар захирамж, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/148 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ординат” ХХК-тай байгуулсан “Тоног төхөөрөмж нийлүүлэх /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хорооны 78, 117 дугаар цэцэрлэг, 67 дугаар сургууль болон 9 дүгээр хороо/” СХД/ТТ/2019/А/294 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Тоног төхөөрөмж нийлүүлэх /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хорооны 78, 117 дугаар цэцэрлэг, 67 дугаар сургууль болон 9 дүгээр хороо/” нийлүүлэх ажлын тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001723

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 04 өдрийн 0/50 дугаар тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

С.Ариунжаргал Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Ганбаяр Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Бүрэнжаргал Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн /Зөвшилцсөнөөр/

Б.Бямбажаргал Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хороо хариуцсан мэргэжилтэн /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

А.Эрдэнэмөнх Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн